



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/455

Мөрөн сум

Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг нэмэгдүүлэхэд зориулж Мал хамгаалах сангаас 150,000,000 (Нэг зуун тавин сая төгрөг) зарцуулсугай.

2.Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



ХАА
Х Хөдөө аж ахуйн салбар
Х Хөдөө аж ахуйн салбар
Х Хөдөө аж ахуйн салбар
Х Хөдөө аж ахуйн салбар

2024.09.06/14

6712011352

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА П.ЛХАГВАЖАВ

2024 оны 04 сарын 05 өдөр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зорилго: Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолоор өгсөн аймгийн аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийн нөөц бэлтгэхэд энэхүү тендерийн зорилго оршино.

| Багцын номер | Барааны нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнийн дүн | Санхүүжилтийн эх үүсвэр |
|--------------|-------------|-------------|------------|----------------|----------------|-------------------------|
| Багц-1 | Өвс | Боодол | 2500 | 16000 | 40,000,000 | Мал хамгаалах сан |
| Багц-2 | Өвс | Боодол | 2500 | 16000 | 40,000,000 | Мал хамгаалах сан |
| Багц-3 | Хивэг | Шуудай | 3180 | 22000 | 69,960,000 | Мал хамгаалах сан |
| Нийт | | | | | 149,960,000 | |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ (БАГЦ 1, 2 -ӨВС)

1. Өвс Техникийн шаардлага: MNS592:2008 5х стандартын шаардлага хангасан байна.

(Шинээр бэлтгэсэн ногоон, цайвар ногоон өнгөтэй, өвсний өвөрмөц анхилам үнэртэй, гадны ямарваа нэг хольцгүй, цэвэр байна)

| № | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Хэмжээ |
|------------------|---------------------------|-------------|---------------------|
| 1 | Сөөг, Сөөгөнцөр ургамал | хувь | 10-аас доошгүй |
| 2 | Хорт ба хөнөөлт ургамал | хувь | 0,5-аас дээшгүй |
| 3 | Хагд өвсний хэмжээ | хувь | 15-аас дээшгүй |
| 4 | Чийг | хувь | 15-аас дээшгүй |
| 5 | Нийт эслэг | хувь | 28-аас дээшгүй |
| 6 | Элс, шорооны холц | хувь | 0,5-аас дээшгүй |
| 7 | Нийт протейн | хувь | 10-аас доошгүй |
| 8 | Каротины хэмжээ | хувь | 20-аас доошгүй |
| 9 | Нэг боодол өвсний нягтрал | Кг/м3 | 120-150 аас доошгүй |
| Ажлын тоо хэмжээ | | | |
| 1 | Нэг боодол өвсний хэмжээ | См | 50x36x80 |
| 2 | Баглаа боодлын жин | Кг | 18-аас доошгүй |
| 3 | Нийлүүлэх өвс | боодол | 5000 |
| 4 | Нийлүүлэх өвсний масс | тн | 90,0 тн |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ (БАГЦ-3 ХИВЭГ)

2. Малын нэмэгдэл тэжээл буюу хивэг.


Техникийн шаардлага: MNS961:2008 3х стандартын шаардлага хангасан байна. /Буудайн хальс ба гурлын үлдэгдэл нунтаг бүхий, жигд боровтор туяатай улаан шаргал өнгөтэй, түүхий эдийн өвөрмөц үнэртэй, гадны ямар нэгэн үнэргүй/

Тэжээлийг хадгалах MNS5364:2004 стандарт, тээвэрлэх MNS5647:2006 стандартуудыг мөрдөнө.

| № | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Хэмжээ |
|-------------------------|------------------------------|-------------------------------|---------------|
| 1 | 1 кг тэжээлд байх төмөр | Мг-аас ихгүй | 30,0 |
| 2 | Агуулахын хортон | | Байж болохгүй |
| 3 | Меламин | Мг/кг-аас ихгүй | 2,5 |
| 4 | Пестицид | Мг/кг-аас ихгүй | 0,1 |
| 5 | Тос | Хувиас ихгүй | 2,8 |
| 6 | Үнс | Хувиас ихгүй | 6,0 |
| 7 | 1кг-д байх солилцлын энерги | МДЖ/ багагүй (хивэгч мал)/ | 8,8 |
| 8 | Нийт протейн, хувиас ихгүй | хувь | 12,7 |
| 9 | Нийт эслэг, хувиас | хувь | 8,0 |
| 10 | Чийг, хувиас ихгүй | хувь | 15,0 |
| Ажлын тоо хэмжээ | | | |
| 1 | Нэг шуудай тэжээлийн жин | Кг | 25 |
| 2 | Нийлүүлэх тэжээл | Шуудай | 1600 |
| 3 | Нийлүүлэх тэжээлийн нийт жин | тонн | 40 |

1. Баглаа, боодол: MNS 0592:2008 Улсын стандартыг хангасан байх.
2. Чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг гаргуулсан байх
3. Бараа хүргэх газар: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Аймгийн аюулгүй нөөцийн хашаанд
4. Ачилт, буулгалт, хураалтын зардлыг тухайн аж ахуйн нэгж хариуцах
5. Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоно.
6. Малын гоц халдварт өвчингүй бүс нутгаас авах.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:
МАЛ ҮРЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА  Б.БЯМБАСҮРЭН

ХЯНАСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  Я.ЭРХЭМБАЯР

